

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/147/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2022ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Одбилэг

Утас: 70273465 Цахим хаяг: odbilegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.22 № 01/50
талай _____ -ны № _____ -т

Г **Хязгаарлалтай дүгнэлт** Г

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.БАТЦЭЦЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Жилийн эцсийн тооллогыг гүйцэтгэхдээ 138,692.0 мянган төгрөгийн бараа материалыг биетээр тоолоогүй, 9,823,7 мянган төгрөгийн аж ахуйн материалыг их хэмжээгээр бэлтгэн, үр ашиггүй удаан хадгалсан зөрчил илэрлээ. Энэ нь бараа материалын хувьд тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Иж бүрэн байх", "Оршин байх", "Тасалбар болголт" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 2023 оны 241 дугаар "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоол, Засгийн газрын газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр "Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоолоор албан хаагчдын цалинд өөрчлөлт орж нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 117,265.2 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээр 583,837.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд тусган тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	133,984,190.0	138,692,004.0
33	АВЛАГА	0.0	1,587,566.0
335	Бусад авлага	0.0	1,587,566.0
3351	Байгууллагаас авах авлага	0.0	1,587,566.0
35	БАРАА МАТЕРИАЛ	133,984,190.0	137,104,438.0
351	Түүхий эд материал	180,000.0	180,000.0
35130	Эм боох материал	180,000.0	180,000.0
354	Хангамжийн материал	101,399,190.0	104,519,438.0
35410	Бичиг хэргийн материал	5,005,195.0	4,815,575.0
35420	Аж ахуйн материал	77,077,946.0	86,901,713.0
35430	Сэлбэг хэрэгсэл	7,948,499.0	0.0
35470	Бусад хангамжийн материал	11,367,550.0	12,802,150.0
35600	Мал амьтад	32,405,000.0	32,405,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,477,383,897.1	2,263,471,622.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,477,383,897.1	2,263,471,622.4
392	Биет хөрөнгө	1,474,299,897.1	2,260,387,622.4
39201	Барилга, байгууламж, орон сууц	978,357,092.2	1,399,939,173.2
39202	Хуримтлагдсан элэгдэл	-59,990,449.4	-79,536,564.8
39203	Авто-тээврийн хэрэгсэл	198,420,921.0	343,777,521.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-143,750,977.1	-117,873,584.6
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	94,399,460.0	148,057,660.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31,355,936.7	-51,975,539.7
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,360,225.0	55,318,325.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,654,542.0	-26,708,229.2
39214	Бусад үндсэн хөрөнгө	785,348,064.0	1,034,095,472.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-371,833,960.0	-444,706,610.7
393	Биет бус хөрөнгө	3,084,000.0	3,084,000.0
39301	Програм хангамж	2,035,000.0	2,035,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,285,000.0	-1,285,000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	2,334,000.0	2,334,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,611,368,087.1	2,402,163,626.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	4,733,566.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	4,733,566.2
413	Өглөг	0.0	4,733,566.2
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	936,441.2
4136	Бусад өглөг	0.0	3,797,125.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	3,797,125.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,611,368,087.1	2,397,430,060.1
51	Засгийн газрын хувь оролцоо	1,611,368,087.1	2,397,430,060.1

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	477,550,843.0	477,550,843.0
51101	Өмч: - төрийн	477,550,843.0	477,550,843.0
512	Хуримтлагдсан үр дүн	831,289,598.4	1,617,351,571.4
51210	Өмнөх үеийн үр дүн	831,289,598.4	831,289,598.4
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	786,061,973.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	302,527,645.7	302,527,645.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,611,368,087.1	2,402,163,626.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	888,474,111.7	1,778,717,819.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	270,486,800.0	632,972,590.7
120	Нийтлэг татварын бус орлого	270,486,800.0	632,972,590.7
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	270,486,800.0	632,972,590.7
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	0.0	21,024,491.7
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	270,486,800.0	611,948,099.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	617,987,311.7	1,145,745,229.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	186,919,611.7	271,672,951.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.0	104,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	134,718,094.0	242,811,691.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	52,201,517.7	28,757,260.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	431,067,700.0	874,072,278.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	431,067,700.0	874,072,278.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	590,298,536.9	993,082,846.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	586,005,086.9	981,967,546.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	525,091,250.0	833,036,220.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,974,922.2	372,864,577.0
210101	Үндсэн цалин	166,893,586.3	247,944,463.7
210102	Нэмэгдэл	30,733,632.9	79,621,483.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,590,296.8	4,167,065.0
210104	Урамшуулал	10,377,985.0	34,000,139.6

210105	Гэрээт ажлын хөлс	7,379,421.2	7,131,425.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,449,405.6	46,390,302.8
210201	Тэтгэврийн даатгал	18,710,900.8	31,693,859.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,207,952.8	3,728,689.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,766,122.2	3,289,748.8
210204	Ажилгүйдлийн даатгал	426,939.8	693,338.8
210205	Эрүүл мэндийн даатгал	4,337,490.0	6,984,666.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,091,109.0	44,353,629.5
210301	Гэрэл, цахилгаан	2,906,510.0	4,767,743.0
210302	Түлш, халаалт	32,184,599.0	39,585,886.5
2104	Хангамж, бараа материалын зардал	56,671,048.0	51,933,986.0
210401	Бичиг хэрэг	1,955,500.0	4,901,120.0
210402	Тээвэр, шатахуун	24,990,070.0	25,813,466.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.0	2,186,500.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,525,478.0	19,032,900.0
2105	Нормативт зардал	361,000.0	577,650.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	361,000.0	577,650.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,209,258.0	21,205,282.0
210604	Урсгал засвар	9,209,258.0	21,205,282.0
2107	Томилолт, зочны зардал	4,306,100.0	5,364,000.0
210702	Дотоод албан томилолт	4,306,100.0	5,364,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,430,082.3	55,538,717.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,243,637.3	47,594,772.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.0	7,500,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	96,525.0	96,525.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	523,920.0	325,420.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	242,000.0	22,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	139,598,324.9	234,808,075.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,010,317.7	84,831,412.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,588,007.2	149,976,663.7

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,913,836.9	148,931,326.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,332,200.0	3,200,000.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,832,200.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.0	3,200,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	34,581,636.9	145,731,326.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,581,636.9	145,731,326.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,293,450.0	11,115,300.0
2200	Дотоод эх үүсвэрээр	4,293,450.0	11,115,300.0
221001	Их засвар	0.0	2,000,000.0
223001	Бусад хөрөнгө	4,293,450.0	9,115,300.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	298,175,574.9	785,634,973.0
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	427,000.0
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	0.0	427,000.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.0	427,000.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	298,175,574.9	786,061,973.0

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	618,087,311.7	1,166,769,720.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	100,000.0	21,024,491.7
120	Нийтлэг татварын бус орлого	100,000.0	21,024,491.7
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,000.0	21,024,491.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.0	0.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	0.0	21,024,491.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	617,987,311.7	1,145,745,229.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	186,919,611.7	271,672,951.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.0	104,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	134,718,094.0	242,811,691.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	52,201,517.7	28,757,260.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	431,067,700.0	874,072,278.0

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	431,067,700.0	874,072,278.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	489,056,311.7	1,049,504,520.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	489,056,311.7	1,049,504,520.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	428,142,474.8	901,273,194.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,974,922.2	376,771,541.7
210101	Үндсэн цалин	166,893,586.3	253,761,611.1
210102	Нэмэгдэл	30,733,632.9	80,413,640.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,590,296.8	4,085,945.0
210104	Урамшуулал	10,377,985.0	31,601,929.0
210105	Гэрээт ажлын хөлс	7,379,421.2	6,908,416.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,449,405.6	46,307,045.9
210201	Тэтгэврийн даатгал	18,710,900.8	31,601,740.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,207,952.8	3,797,696.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,766,122.2	3,252,196.7
210204	Ажилгүйдлийн даатгал	426,939.8	716,816.5
210205	Эрүүл мэндийн даатгал	4,337,490.0	6,938,596.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,091,109.0	45,941,195.5
210301	Гэрэл, цахилгаан	2,906,510.0	4,767,743.0
210302	Түлш, халаалт	32,184,599.0	41,173,452.5
2104	Хангамж, бараа материалын зардал	25,154,440.0	30,103,174.0
210401	Бичиг хэрэг	1,276,000.0	2,931,900.0
210402	Тээвэр, шатахуун	21,994,850.0	24,858,174.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.0	2,313,100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	683,590.0	0.0
2105	Нормативт зардал	500,000.0	1,000,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.0	1,000,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,998,438.0	6,300,000.0
210604	Урсгал засвар	10,998,438.0	6,300,000.0
2107	Томилолт, зочны зардал	4,356,100.0	5,364,000.0
210702	Дотоод албан томилолт	4,356,100.0	5,364,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,528,461.4	50,937,414.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,474,016.4	42,417,994.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.0	7,824,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	96,525.0	200,000.0

210804	Тээврийн хэрэгслийн татвар	523,920.0	325,420.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110,000.0	170,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,089,598.6	338,548,823.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,089,598.6	338,548,823.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,913,836.9	148,231,326.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,332,200.0	2,500,000.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,832,200.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.0	2,500,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	34,581,636.9	145,731,326.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,581,636.9	145,731,326.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	129,031,000.0	117,265,200.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	129,364,000.0	117,265,200.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	129,364,000.0	117,265,200.0
2200	Дотоод эх үүсвэрээр	129,364,000.0	117,265,200.0
223001	Бусад хөрөнгө	129,364,000.0	0.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.0	117,265,200.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-129,364,000.0	-117,265,200.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-333,000.0	0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	333,000.0	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	477,550,843.0	302,527,645.7	533,114,023.6	1,313,192,512.2
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	477,550,843.0	302,527,645.7	533,114,023.6	1,313,192,512.2
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	298,175,574.9	298,175,574.9
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	477,550,843.0	302,527,645.7	831,289,598.4	1,611,368,087.1

D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	477,550,843.0	302,527,645.7	831,289,598.4	1,611,368,087.1
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	477,550,843.0	302,527,645.7	831,289,598.4	1,611,368,087.1
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	784,474,407.0	784,474,407.0
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	477,550,843.0	302,527,645.7	1,615,764,005.4	2,395,842,494.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	728,659,100.0	623,802,182.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	728,659,100.0	623,802,182.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	727,659,100.0	621,302,182.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	377,992,600.0	362,006,018.6
210101	Үндсэн цалин	296,898,200.0	252,337,549.1
210102	Нэмэгдэл	47,484,200.0	62,637,725.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,000,000.0	9,224,799.3
210104	Урамшуулал	16,610,200.0	30,897,529.0
210105	Гэрээт ажлын хөлс	0.0	6,908,416.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,249,100.0	44,556,122.9
210201	Тэтгэврийн даатгал	32,129,400.0	30,335,073.6
210202	Тэтгэмжийн даатгал	3,780,000.0	3,676,964.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,023,900.0	3,129,541.4
210204	Ажилгүйдлийн даатгал	756,000.0	692,670.2
210205	Эрүүл мэндийн даатгал	7,559,800.0	6,721,873.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,018,300.0	45,941,195.5
210301	Гэрэл, цахилгаан	4,854,600.0	4,767,743.0
210302	Түлш, халаалт	49,063,700.0	41,173,452.5
210303	Цэвэр, бохир ус	100,000.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	23,023,900.0	26,120,650.0
210401	Бичиг хэрэг	2,000,000.0	2,086,900.0
210402	Тээвэр, шатахуун	18,623,900.0	21,720,650.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.0	2,313,100.0
2105	Нормативт зардал	1,000,000.0	1,000,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.0	1,000,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,300,000.0	6,300,000.0
210604	Урсгал засвар	6,300,000.0	6,300,000.0
2107	Томиллолт, зочны зардал	5,347,000.0	5,364,000.0
210702	Дотоод албан томиллолт	5,347,000.0	5,364,000.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,390,400.0	49,797,414.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,880,400.0	41,277,994.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.0	7,824,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.0	200,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	816,000.0	325,420.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	170,000.0	170,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	164,337,800.0	80,216,781.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	164,337,800.0	80,216,781.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.0	2,500,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.0	2,500,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.0	2,500,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	137,700,000.0	117,265,200.0
2200	Дотоод эх үүсвэрээр	137,700,000.0	117,265,200.0
221001	Их засвар	54,400,000.0	34,576,300.0
222001	Тоног төхөөрөмж	15,000,000.0	14,847,060.0
223001	Бусад хөрөнгө	68,300,000.0	67,841,840.0
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	866,359,100.0	866,359,500.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	866,359,100.0	866,359,500.0
132001	Орон нутгийн төсвөөс	866,359,100.0	866,359,500.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	7	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	186,919,611.70	279,971,012.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,919,611.70	279,971,012.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,062,920.00	279,971,012.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	14,765,523.09
210101	Үндсэн цалин	00.00	1,424,061.96
210102	Нэмэгдэл	00.00	12,637,061.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
210104	Урамшуулал	00.00	704,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	1,750,922.94
210201	Тэтгэврийн даатгал	00.00	1,266,666.49
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	120,731.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	122,655.32
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	24,146.34
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	216,723.12
2104	Хангамж, бараа материалын зардал	2,976,640.00	3,982,524.00
210401	Бичиг хэрэг	2,293,050.00	845,000.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	3,137,524.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	683,590.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	1,140,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,140,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,086,280.00	258,332,042.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,086,280.00	258,332,042.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,832,200.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,832,200.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,832,200.00	00.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,024,491.70	00.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	21,024,491.70	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	100,000,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	100,000,000.00	00.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	100,000,000.00	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	186,919,611.70	271,672,951.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	186,919,611.70	271,672,951.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	134,718,094.00	242,811,691.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	52,201,517.70	28,757,260.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

1.1 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагаандаа олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO стандартыг нэвтрүүлэхээр “Менежмент ба арга зүйн төв” ТББ-тай гэрээ байгуулан ажилласан байна.

Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар 15 ажлын байр, албан тушаалын чиг үүрэгт шинжилгээ хийж чиг үүргийн давхардалгүй ажиллаж байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлттэй холбоотойгоор Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох баримт бичигт орсон өөрчлөлтийг тусган мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах,

шаардлагагүй гэж үзсэн

1.2 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2018 онд аймгийн хэмжээнд Санхүү төрийн сангийн хэлтсээс баталсан нББ-ын бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна

1.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46,685.43 мянган төгрөгөөр буюу 1,4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	1,587.6	1,587.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	133,984.2	137,104.4	3,120.2
Үндсэн хөрөнгө	1,477,383.9	2,263,471.6	786,087.7
Нийт хөрөнгө	1,611,368.1	2,402,163.6	790,795.5
Өр төлбөр	-	4,733.6	4,733.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,611,368.1	2,397,430.1	786,062.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,611,368.1	2,402,163.6	790,795.5

Дээрх хүснэгтээс харахад:

Тайлант онд авлага 1,587.6 мянган төгрөгийн түлш халаалтын авлага үүсгэсэн байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 790,795.5 мянган төгрөгөөр буюу 49,1 хувиар өссөн байна.

Бараа материал дансны хувьд аж ахуйн материал 9,823,767.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 1,434,600.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, бичиг хэргийн материал 189,620.0 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 7,948,499.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж, орон сууц 421,582.0 мянган төгрөг, тээврийн хэрэгсэл 145,357.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 53,658.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 57,762.0 мянган төгрөг, шилжүүлсэн 800.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Богино хугацаат өр төлбөрийн дүн 4,733.6 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн өр 936.4 мянган төгрөг, хувь хүнээр гүйцэтгүүлсэн ажлын хөлс 3,797.1 мянган төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,397,430.0 мянган төгрөг болж 786,062.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ

1.4 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 493,735.2 мянган төгрөг, зарлагыг 493,735.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын хүргүүлсэн төсвийн төслөөс 104,254.6 мянган төгрөгөөр бууруулж, аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар тогтоолоор 389,480.6 мянган төгрөгийн төсөв 2023 оны санхүүгийн жилд зарцуулж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлагдаж ирсэн байна.

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 675,525.8 мянган төгрөг, зарлагыг 675,525.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын хүргүүлсэн төсвийн төслөөс 95,294.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, аймгийн ИТХ-ын 2022 оны 13 дугаар тогтоолоор 752,820.4 мянган төгрөг, 2023 оны ээлжит бус 6 дугаар хуралдааны тогтоолоор 740,768.8 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Тайлант хугацаанд сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 02 тоот тогтоолоор тодотгол хийж, нийт 68,500.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг сумын шилжих үлдэгдлээс санхүүжүүлэхээр тодотгол оруулж нийт зардлыг 604,828.3 мянган төгрөгөөр, зардал санхүүжүүлэх эх үүсвэрийг 604,828.3 мянган төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр болсон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 389,480.6 мянган төгрөгийг 218,210.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1 удаа тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэх 604,700.6 мянган төгрөг, хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэх 2,900.0 мянган төгрөг, нийт 607,600.6 мянган төгрөгийн зардлыг, орон нутгийн төсвөөс 389,480.6 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс 218,120.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсны дагуу гүйцэтгэлээр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 100 хувь олгож, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 23,587.0 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 584,013.6 мянган төгрөг буюу 96,1 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, цалингийн зардлаас 12,773.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 3,089.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 1,301.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх бараа үйлчилгээний зардлаас 6,257.7 мянган төгрөг нийт 23,587.0 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80101 /Үндсэн үйл ажиллагааны зардал	2023.01.01 2023.12.31			405,520.00	405,520.00
2	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80103 /Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ		56,380.40	56,380.40
3	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80106 /Баг, хорооны үйл ажиллагааны зардал	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Баг, хорооны үйл ажиллагааны зардал		99,720.90	99,720.90
4	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80802 /Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг		1,000.00	1,000.00
5	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80918 /Бусад	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Бусад		55,000.00	55,000.00
6	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-81102 /Орон нутгийн нөөц хөрөнгө	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Орон нутгийн нөөц хөрөнгө		5,000.00	5,000.00
7	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-82212 /Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ		1,700.00	1,700.00
8	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-81701 /Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх		78,437.80	78,437.80
9	70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-82212 /Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ			
	Дүн				702,759.10	702,759.10

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 онд нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Тө.ХО барьцаа сангаас Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөрийн санхүүжилт 100,000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргаас автомашины

засварт 5,500.0 мянган төгрөг, онцгой байдлын штабд шатахууны дэмжлэг 5,000.0 мянган төгрөг, статистикийн хэлтсээс ээлжит тооллогын болон тандалт судалгааны зардалд 1,102.8 мянган төгрөг, ТАХ-д олгох орон нутгийн нэмэгдэлд 33,796.2 мянган төгрөг, өвсний үнэнд 19,459.5 мянган төгрөг, өмнөх оны татан төвлөрүүлсэн нэмэлт санхүүжилтийн орлого 20,702.3 мянган төгрөг, бусад орлого 6,720.5 мянган төгрөг нийт 192,326.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж холбогдох зардлуудад зориулалтын дагуу зарцуулсан байна. Тайлант онд зарцуулаагүй 9,974.3 мянган төгрөгийг татан төвлөрүүлж тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого, зардлыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 100,700.0 мянган төгрөг батлагдсан байна. Гүйцэтгэлээр 74,744.5 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны журмын дагуу зохион байгуулсан байна. Худалдан авалтын дүн өссөн нь төсөв тодотгон нэмэгдсэнтэй холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одбилэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02/38 тоот албан бичгээр Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын батлагдсан 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 888,474.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,884.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7,107.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох гэсэн” заалтыг зөрчиж улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл 13,029.8 мянган төгрөг олгосон байна

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор

баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээ болон төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш зарлагын 2 гүйлгээг байршуулаагүй шилэн дансны хэрэгжилт 48.5 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын тамгын газар нь санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 03/125 тоотой Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	311.0	1	311.0	100%
Албан шаардлага	1	10,500.0	1	10,500.0	100%
Зөвлөмж	1	12,371.2	1	12,371.2	100%
Нийт дүн	3	23,182.2	3	23,182.2	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдон гарсан зардлыг шалгах асуудал тодорхойлж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,234,204.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлснийг дараах байдлаар шийдвэрлэлээ.

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 63,025.2 мянган төгрөгийн алдаа залруулагдсан болно

1. Илрүүлэлт: Дулаанаар хангагч Өв баян-Улаан ХХК-д халаалтын үнийг илүү шилжүүлж авлагаар бүртгээгүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн

тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Илрүүлэлт: Бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн хандиваар болон шилжүүлэн авсан ??? дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан дүнтэй тулгахад 28,110.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн уялдааг тулгаж үзэхэд мөнгөн гүйлгээний тайланг 29,337.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4. Илрүүлэлт: Үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг зэрэгцүүлэн тулгахад цалин хөлс нэмэгдэл урамшил 3,907.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 83.3 мянган төгрөгөөр, зөрүүтэй байна. Энэ нь УСНББОУС-ын 1, 2, 29, 30 болон НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 1,171,178.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 13,029.8 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,157,212.6 мянган төгрөгийн 1 зөрчилд х албан шаардлага, 936.4 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

5.2 Төлбөрийн акт

1. Илрүүлэлт: Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгоно гэсэн Монгол улсын Засгийн газрын тогтоолыг зөрчиж улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгож төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчил илэрлээ

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр

тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай ” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтооно” гэсний дагуу шийдвэрлэв.

а. Албан шаардлага

1. Илрүүлэлт: Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Хөрөнгийн тооллого хийх тухай” А/09 тушаалын эд хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д “Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/”, мөн хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-д “Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх” гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг”, “Тасалбар болголт”, “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

2. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээ болон төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш зарлагын 2 гүйлгээг байршуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8-д “... хөрөнгө, мөнгө зарцуулах, ... шийдвэр”, гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг”, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох албан тушаалтанд Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулахаар албан шаардлага бичив.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлагналтай холбоотой алдаа	4	63,025.2			4	63,025.2						
Дүн	4	63,025.2			4	63,025.2						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Алдааны товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс:				Хууль хяналтын байгууллагад	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан			
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Улс төрийн албан хаагчдад журам зөрчиж орон нутгийн нэмэгдэл олгосон байна.	1	13,030	1	13,030								
Хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоо бодож баталгаажуулаагүй байна.	1	-			1	-						
Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаагүй.	1	1,157,213			1	1,157,213			1	1,157,213		
Өр, авлага үүсгэхгүй байх.	1	936					1	936				
Дүн	4	1,171,179	1	13,030	2	1,157,213	1	936	1	1,157,213	-	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn